



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатарын Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Төсөв, кредит цагийн төлбөрийн хэмжээ батлах тухай” 01 дүгээр тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 227,440,000.00 (хоёр зуун хорин долоон сая дөрвөн зуун дөчин мянган) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Улаанбаатарын Их Сургуулийн захирал С.Байгалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000086

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 02 дугаар сарын 11-ний
өдрийн.../8... дугаар тогтоолын хавсралт

Улаанбаатарын Их Сургуулийн 2020 онд хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр төрөл, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Төсөвт өртөг
				(мян.төгрөг)
	1. Барилга, их засвар			103,000.00
1	Сантехникийн засвар	багц	1	100,000.00
2	Гэрэлтүүлгийн ажил (Лед гэрэл)	ш	60	3,000.00
	2.Тавилга эд хогшил			114,440.00
3	Шатаах зуух	ш	1	3,000.00
4	Сокслетийн аппарат	ш	1	1,000.00
5	Компьютер /I7 lenovo/	ш	30	69,000.00
6	Нөтбүүк Dell	ш	4	7,920.00
7	Цахилгаан мотор /сэнстэй/	ш	1	500.00
8	Принтер	ш	4	1,540.00
9	Ангийн самбар	ш	20	9,600.00
10	Багш ширээ	ш	20	13,000.00
11	Ширээ (албаны)	ш	5	3,000.00
12	Ширээ (албаны урт)	ш	2	1,660.00
13	Шилэн шкаф	ш	2	1,820.00
14	Сандал	ш	20	2,400.00
	Ном, сурах бичиг			10,000.00
15	Ном, сурах бичиг			10,000.00
	Барилга, их засварын дүн		3	103,000.00
	Тавилга эд хогшлын дүн		200	114,440.00
	Ном сурах бичгийн дүн			10,000.00
				227,440.00
	Нийт дүн		226	(хоёр зуун хорин долоон сая дөрвөн зуун дөчин мянган)